



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Аймгийн Нийгмийн даатгалын сангийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2021/7/СТА-ТТЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Сайншанд сум

2021 он

Дарга, тэргүүлэх аудиторын үүргийг түр орлон гүйцэтгэгч:  
Т.Ган-Өлзий

Утас: 7052-2734

Цахим хаяг: Gan-Ulziit@audit.gov.mn

Аудитын менежер: У.Оюунтүлхүүр

Утас: 7052-3020 Цахим хаяг:

Oyuntulkhuur.u@audit.gov.mn

Аудитор: Ч.Хэрлэнчимэг

Утас: 70523020 Цахим хаяг:

Kherlenchimegch@audit.gov.mn

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НДЕГ	Нийгмийн даатгалын ерөнхий газар

## Агуулга

---

1.Төрийн аудитын санал, дүгнэлт .....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	11
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	13
3.Аудитын тайлан.....	14
3.1. Ерөнхий зүйл.....	14
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	14
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт .....	14
3.4. Материаллаг байдал .....	15
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	15
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт .....	16
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	18
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	18
3.9. Аудитын илрүүлэлт.....	18
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил .....	18
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд .....	19
4. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	20

## 1.Төрийн аудитын санал, дүгнэлт



### ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,  
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,  
Утас: (705) 2-27-34  
Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2021.09.25 № 1-6/311

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН  
ХЭЛТСИЙН ДАРГА Л.ШАГДАРСҮРЭН  
ТАНАА

#### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Нийгмийн даатгалын сангийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Нийгмийн даатгалын сангийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Бусад мэдээлэл

Байгууллагын жилийн тайлан, санхүүгийн тайлан ба аудитын тайланд тусгагдсанаас бусад санхүүгийн ба санхүүгийн бус мэдээлэл байхгүй болно.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.


#### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБООУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН  
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Т.ГАН-ӨЛЗИЙ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

төгрөгөөр			
Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>6,593,521,856.61</b>	<b>12,008,289,083.07</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	5,414,306,252.31	6,475,253,060.15
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	5,414,306,252.31	6,475,253,060.15
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	5,414,306,252.31	6,475,253,060.15
31211	Төрийн сангийн харилцах	4,000,000.00	268,000.00
31213	Арилжааны банк дахь харилцах	5,410,306,252.31	6,474,985,060.15
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	1,167,847,826.29	5,515,780,294.71
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	1,083,818,961.51	1,476,052,190.18
33300	Татаас, санхүүжилтийн авлага	00.00	3,971,505,547.53
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	84,028,864.78	68,222,557.00
3351	Байгууллагаас авах авлага	84,028,864.78	68,222,557.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	11,367,778.01	17,255,728.21
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	11,367,778.01	17,255,728.21
35410	Бичиг хэргийн материал	171,100.01	445,530.01
35420	Аж ахуйн материал	6,269,000.00	12,290,887.00
35440	Түлш, шатах тослох материал		1,085,000.00
35450	Барилгын засварын материал	00.00	168,200.00
35470	Бусад хангамжийн материал	4,927,678.00	3,266,111.20
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>444,547,197.78</b>	<b>429,740,397.07</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	444,547,197.78	429,740,397.07
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	419,347,197.78	404,540,397.07
39201	Барилга, байгууламж, орон сууц	351,060,639.99	351,060,639.99
39202	Хуримтлагдсан элэгдэл	-11,651,677.06	-23,644,166.48
39203	Авто-тээврийн хэрэгсэл	88,900,000.00	69,900,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-72,395,833.33	-65,045,833.33
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	114,930,485.00	145,045,656.38
39206	Хуримтлагдсан элэгдэл	-82,162,392.64	-97,271,665.31
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	63,463,668.00	61,702,100.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-32,797,692.18	-37,206,334.18
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	25,200,000.00	25,200,000.00
39301	Програм хангамж	5,427,586.00	5,427,586.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-5,427,586.00	-5,427,586.00
39303	Бусад биет бус хөрөнгө	25,200,000.00	25,200,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>7,038,069,054.39</b>	<b>12,438,029,480.14</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>428,091,694.10</b>	<b>142,289,309.62</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>428,091,694.10</b>	<b>142,289,309.62</b>
<b>413</b>	<b>Өглөг</b>	373,539,495.20	55,410,960.40
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	373,539,495.20	55,410,960.40
<b>414</b>	<b>Урьдчилж орсон орлого</b>	54,552,198.90	86,878,349.22
41410	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	54,552,198.90	86,878,349.22
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>6,609,977,360.29</b>	<b>12,295,740,170.52</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	6,609,977,360.29	12,295,740,170.52
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	366,264,211.87	366,264,211.87
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	6,221,068,001.02	11,906,830,811.26
51210	Өмнөх үеийн үр дүн	5,552,613,769.25	6,237,868,318.26
51220	Тайлант үеийн үр дүн	668,454,231.77	5,668,962,493.00
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	22,645,147.40	22,645,147.39
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>7,038,069,054.39</b>	<b>12,438,029,480.14</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

төгрөгөөр

**Нийгмийн даатгалын сангийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>53,084,679,743.29</b>	<b>68,029,588,919.99</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>41,766,876,129.66</b>	<b>48,756,631,492.14</b>
<b>112</b>	<b>Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого</b>	41,766,876,129.66	48,756,631,492.14
112001	Тэтгэврийн даатгалын шимтгэл	28,178,600,807.77	33,381,926,690.69
112002	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	2,958,333,283.01	3,427,897,867.31
112003	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	3,078,762,877.22	3,325,715,808.52
112004	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	698,518,578.97	671,795,774.39
112005	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	6,852,660,582.69	7,949,295,351.23
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>257,194,913.63</b>	<b>174,087,843.27</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	257,194,913.63	174,087,843.27
120002	Хүүгийн орлого	206,099,276.84	153,014,699.21
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	51,095,636.79	21,073,144.06
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	21,440,980.79	10,629,327.06
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	387,600.00	449,600.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	8,329,850.00	
120009	Бусад орлого	20,937,206.00	9,994,217.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>11,060,608,700.00</b>	<b>19,098,869,584.58</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	00.00	233,600,000.00
131004	Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх	00.00	233,600,000.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	3,681,000.00	5,674,360.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	1,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,681,000.00	4,674,360.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>		
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/		
<b>1330</b>	<b>Төсвийн захирагчдаас</b>	10,400,500,000.00	18,161,060,524.58
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,400,500,000.00	18,161,060,524.58
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	656,427,700.00	698,534,700.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	656,427,700.00	698,534,700.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>52,416,225,511.52</b>	<b>62,360,626,426.99</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>52,416,225,511.52</b>	<b>62,360,626,426.99</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	626,393,774.45	673,563,123.90
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	420,576,952.00	475,148,485.00
210101	Үндсэн цалин	353,871,122.00	382,151,217.00
210102	Нэмэгдэл	56,243,830.00	64,765,268.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,462,000.00	22,112,000.00
210104	Урамшуулал		6,120,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	53,763,862.27	59,856,670.30
210201	Тэтгэврийн даатгал	35,989,529.40	40,068,055.10
210202	Тэтгэмжийн даатгал	4,446,271.41	4,950,146.63
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,553,791.30	3,956,525.91
210204	Ажилгүйдлийн даатгал	887,103.73	987,635.06
210205	Эрүүл мэндийн даатгал	8,887,166.43	9,894,307.60
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	26,486,864.51	27,750,632.33
210301	Гэрэл, цахилгаан	3,913,383.51	4,080,929.33
210302	Түлш, халаалт	21,099,621.00	17,834,384.00
210303	Цэвэр, бохир ус	1,473,860.00	935,319.00
210304	Байрны түрээс	00.00	4,900,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	20,105,291.50	21,847,793.51
210401	Бичиг хэрэг	5,053,390.00	5,163,970.00
210402	Тээвэр, шатахуун	8,903,800.00	8,978,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,240,409.50	3,640,954.51
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	227,200.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,680,492.00	3,824,769.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	10,696,866.00	2,595,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,830,600.00	1,547,000.00
210604	Урсгал засвар	8,866,266.00	1,048,400.00
<b>2107</b>	<b>Томилот, зочны зардал</b>	4,661,000.00	1,630,100.00

**Нийгмийн даатгалын сангийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210702	Дотоод албан томилолт	4,661,000.00	1,630,100.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>37,743,112.44</b>	<b>36,106,570.68</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	22,426,318.44	19,937,766.68
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,408,000.00	2,660,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,399,573.00	1,390,590.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	148,500.00	107,720.00
210807	Газрын төлбөр	304,920.00	44,400.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	4,210,120.00	4,665,540.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	7,845,681.00	7,300,554.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>52,359,825.73</b>	<b>48,627,472.08</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,729,400.00	1,600,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	49,630,425.73	47,027,472.08
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>51,789,831,737.07</b>	<b>61,687,063,303.09</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>42,567,148,181.00</b>	<b>50,263,458,042.00</b>
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	42,497,175,081.00	50,185,157,818.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	12,788,000.00	14,307,724.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	57,185,100.00	63,992,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>9,222,683,556.07</b>	<b>11,423,605,261.09</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,222,683,556.07	11,423,605,261.09
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>668,454,231.77</u></b>	<b><u>5,668,962,493.00</u></b>
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>		
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>668,454,231.77</u></b>	<b><u>5,668,962,493.00</u></b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>53,524,262,787.85</b>	<b>63,742,441,040.35</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>42,160,672,375.54</b>	<b>44,674,066,648.26</b>
<b>112</b>	<b>Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого</b>	42,160,672,375.54	44,674,066,648.26
112001	Тэтгэврийн даатгалын шимтгэл	28,440,504,116.92	30,304,409,004.51
112002	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	2,989,165,514.96	3,009,943,454.23
112003	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	3,107,190,870.27	2,899,698,594.03
112004	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	707,438,228.43	592,492,972.06
112005	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	6,916,373,644.96	7,867,522,623.43
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>302,981,712.31</b>	<b>243,865,332.09</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	302,981,712.31	243,865,332.09
120002	Хүүгийн орлого	206,099,276.84	153,014,699.21
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	92,882,435.47	90,850,632.88
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	92,494,835.47	90,401,032.88
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	387,600.00	449,600.00
120009	Бусад орлого	4,000,000.00	00.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>11,060,608,700.00</b>	<b>18,824,509,060.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	3,681,000.00	5,674,360.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	1,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,681,000.00	5,674,360.00
<b>1330</b>	<b>Төсвийн захирагчдаас</b>	10,400,500,000.00	18,120,300,000.00
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,400,500,000.00	18,120,300,000.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	656,427,700.00	698,534,700.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	656,427,700.00	698,534,700.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>52,213,495,915.96</b>	<b>62,681,494,232.51</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>52,213,495,915.96</b>	<b>62,681,494,232.51</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>592,666,744.39</b>	<b>623,883,748.82</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	442,770,678.90	475,148,485.00
210101	Үндсэн цалин	399,805,878.90	393,363,385.00
210102	Нэмэгдэл	33,170,400.00	52,345,100.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,794,400.00	23,320,000.00
210104	Урамшуулал	00.00	6,120,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	56,356,496.04	59,856,670.30
210201	Тэтгэврийн даатгал	37,725,038.45	40,068,055.10
210202	Тэтгэмжийн даатгал	4,660,682.22	4,950,146.63
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,725,164.39	3,956,525.91
210204	Ажилгүйдлийн даатгал	929,882.18	987,635.06
210205	Эрүүл мэндийн даатгал	9,315,728.80	9,894,307.60
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	26,486,864.51	27,750,632.33
210301	Гэрэл, цахилгаан	3,913,383.51	4,080,929.33
210302	Түлш, халаалт	21,099,621.00	17,834,384.00
210303	Цэвэр, бохир ус	1,473,860.00	935,319.00
210304	Байрны түрээс	00.00	4,900,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	19,068,007.50	26,328,244.51
210401	Бичиг хэрэг	5,128,490.00	5,438,400.00
210402	Тээвэр, шатахуун	8,623,800.00	10,063,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,240,409.50	3,640,954.51
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	227,200.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,848,108.00	6,945,790.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	10,696,866.00	2,763,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,830,600.00	1,547,000.00
210604	Урсгал засвар	8,866,266.00	1,216,600.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	4,661,000.00	1,630,100.00

Нийгмийн даатгалын сангийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210702	Дотоод албан томилолт	4,661,000.00	1,630,100.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>29,897,431.44</b>	<b>28,806,016.68</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	22,426,318.44	19,937,766.68
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,408,000.00	2,660,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,399,573.00	1,390,590.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	148,500.00	107,720.00
210807	Газрын төлбөр	304,920.00	44,400.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	4,210,120.00	4,665,540.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>2,729,400.00</b>	<b>1,600,000.00</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,729,400.00	1,600,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>51,620,829,171.57</b>	<b>62,057,610,483.69</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>42,398,145,615.50</b>	<b>50,634,005,222.60</b>
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	42,313,659,056.35	50,539,644,323.76
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	12,788,000.00	14,307,724.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	14,513,459.15	16,060,674.84
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	57,185,100.00	63,992,500.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>9,222,683,556.07</b>	<b>11,423,605,261.09</b>
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	9,222,683,556.07	11,423,605,261.09
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>1,310,766,871.89</u></b>	<b><u>1,060,946,807.84</u></b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>1,310,766,871.89</b>	<b>1,060,946,807.84</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>4,103,539,380.42</b>	<b>5,414,306,252.31</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>5,414,306,252.31</b>	<b>6,475,253,060.15</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	366,264,211.87	-	5,524,227,989.60	-	5,913,137,348.87
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	28,385,779.65	-	28,385,779.65
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>366,264,211.87</b>	-	<b>5,552,613,769.25</b>	-	<b>5,941,523,128.52</b>
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	22,645,147.40	-	-	22,645,147.40
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	668,454,231.77	-	668,454,231.77
C08	<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>366,264,211.87</b>	<b>22,645,147.40</b>	<b>6,221,068,001.02</b>	-	<b>6,609,977,360.29</b>
D01	<b>2020 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл</b>	<b>366,264,211.87</b>	<b>22,645,147.40</b>	<b>6,221,068,001.02</b>	-	<b>6,609,977,360.29</b>
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	16,800,317.24	-	16,800,317.24
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>366,264,211.87</b>	<b>22,645,147.40</b>	<b>6,237,868,318.26</b>	-	<b>6,626,777,677.53</b>
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	22,645,147.40	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	5,668,962,493.00	-	5,668,962,493.00
D09	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>366,264,211.87</b>	<b>22,645,147.40</b>	<b>11,906,830,811.26</b>	-	<b>12,295,740,170.53</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>51,819,347,400.00</b>	<b>51,232,403,936.58</b>	586,943,463.42
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>51,819,347,400.00</b>	<b>51,232,403,936.58</b>	586,943,463.42
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	632,443,800.00	619,821,748.82	12,622,051.18
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	475,151,500.00	475,148,485.00	3,015.00
210101	Үндсэн цалин	393,366,400.00	393,363,385.00	3,015.00
210102	Нэмэгдэл	52,345,100.00	52,345,100.00	-
210103	Унаа хоолны хөнгөлөлт	23,320,000.00	23,320,000.00	-
210104	Урамшуулал	6,120,000.00	6,120,000.00	-
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	65,856,900.00	59,856,670.30	6,000,229.70
210201	Тэтгэврийн даатгал	47,244,400.00	40,068,055.10	7,176,344.90
210202	Тэтгэмжийн даатгал	4,653,200.00	4,950,146.63	(296,946.63)
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,722,500.00	3,956,525.91	(234,025.91)
210204	Ажилгүйдлийн даатгал	930,600.00	987,635.06	(57,035.06)
210205	Эрүүл мэндийн даатгал	9,306,200.00	9,894,307.60	(588,107.60)
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	30,301,700.00	27,750,632.33	2,551,067.67
210301	Гэрэл, цахилгаан	4,775,000.00	4,080,929.33	694,070.67
210302	Түлш, халаалт	19,182,200.00	17,834,384.00	1,347,816.00
210303	Цэвэр, бохир ус	1,444,500.00	935,319.00	509,181.00
210304	Байрны түрээс	4,900,000.00	4,900,000.00	-
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	22,770,700.00	22,266,244.51	504,455.49
210401	Бичиг хэрэг	5,441,300.00	5,438,400.00	2,900.00
210402	Тээвэр, шатахуун	10,067,700.00	10,063,100.00	4,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,062,900.00	3,640,954.51	421,945.49
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	315,000.00	240,000.00	75,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,883,800.00	2,883,790.00	10.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	2,764,000.00	2,763,600.00	400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,547,400.00	1,547,000.00	400.00
210604	Урсгал засвар	1,216,600.00	1,216,600.00	-
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	1,712,900.00	1,630,100.00	82,800.00
210702	Дотоод албан томилолт	1,712,900.00	1,630,100.00	82,800.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	32,179,700.00	28,806,016.68	3,373,683.32
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	20,830,300.00	19,937,766.68	892,533.32
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,660,000.00	2,660,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	1,400,000.00	1,390,590.00	9,410.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	148,500.00	107,720.00	40,780.00
210807	Газрын төлбөр	44,400.00	44,400.00	-
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	7,096,500.00	4,665,540.00	2,430,960.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	1,706,400.00	1,600,000.00	106,400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,706,400.00	1,600,000.00	106,400.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	51,186,903,600.00	50,612,582,187.76	574,321,412.24
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	51,186,903,600.00	50,612,582,187.76	574,321,412.24
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	51,113,934,900.00	50,539,644,323.76	574,290,576.24
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	8,976,200.00	8,945,364.00	30,836.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	63,992,500.00	63,992,500.00	-

Нийгмийн даатгалын сангийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>51,819,347,400.00</b>	<b>36,973,198,052.53</b>	<b>14,846,149,347.47</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	9,070,812,400.00	-	9,070,812,400.00
<b>1340</b>	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	42,748,535,000.00	36,953,161,720.62	5,795,373,279.38
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	42,748,535,000.00	36,953,161,720.62	5,795,373,279.38
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	-	20,036,331.91	(20,036,331.91)
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	19,644,469.46	(19,644,469.46)
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	451,939.42	(451,939.42)
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	5,414,306,252.31	(5,414,306,252.31)
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	6,475,253,060.15	(6,475,253,060.15)
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	1.00	1.00	-
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	-
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	42.00	42.00	-
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-
620002	Гүйцэтгэх ажилтан	33.00	33.00	-
620003	Үйлчлэх ажилтан	8.00	8.00	-

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	төгрөгөөр	
		Өмнөх он	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>3,681,000.00</b>	<b>5,674,360.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>3,681,000.00</b>	<b>5,674,360.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,825,000.00	4,062,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	1,100,000.00	4,062,000.00
210402	Тээвэр, шатахуун	1,100,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	4,062,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	325,000.00	-
210702	Дотоод албан томилолт	325,000.00	-
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	400,000.00	-
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	400,000.00	-
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	1,856,000.00	1,612,360.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	1,856,000.00	1,612,360.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,856,000.00	1,612,360.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>3,681,000.00</b>	<b>5,674,360.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>3,681,000.00</b>	<b>5,674,360.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	1,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,681,000.00	4,674,360.00
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>		

### **3.Аудитын тайлан**

#### **3.1. Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасан бүрэн эрхийн хүрээнд Нийгмийн даатгалын сангийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Нийгмийн даатгалын хэлтсийн дарга Л.Шагдарсүрэн танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитыг 2021 оны 03 дугаар сарын 05-наас 2021 оны 03 дугаар сарын 15-ны хооронд Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ч.Хэрлэнчимэг хариуцаж хэрэгжүүлэв.

Нийгмийн даатгалын сангийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 2 дугаар сарын 22-ний өдрийн 54 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй**

Нийгмийн даатгалын байгууллага нь эрхэм зорилгоо “Бид даатгуулагчийнхаа итгэл найдвар, сэтгэл ханамжаар үнэлэгдэх нийгмийн даатгалын үйлчилгээг хүргэнэ” гэж тодорхойлсон байна.

Нийгмийн даатгалын байгууллага дараах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхээр хуульд тусгасан байна. Үүнд:

- нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах;
- нийгмийн даатгалын санг бүрдүүлж, орлого, зарлагын гүйцэтгэлийг хангах;
- нийгмийн даатгалын сангаас тухайн төрлийн тэтгэвэр, тэтгэмжийг цаг тухайд нь олгох ажлыг зохион байгуулж, үйлчилгээг сайжруулах;
- улсын нийгмийн даатгалын тогтолцоо, үйл ажиллагаа, түүний арга хэлбэрийг боловсронгуй болгох талаар судалгаа хийх, санал боловсруулж шийдвэрлэх буюу эрх бүхий байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх;
- доод шатны байгууллагынхаа үйл ажиллагаанд хяналт тавих;
- хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт ороогүй байна.

#### **3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт**

Нийгмийн даатгалын хэлтэс нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Нийгмийн даатгалын Ерөнхий газрын Дотоод аудит, мониторинг болон хяналт, шалгалтын газраас 2020 онд харьяа орон нутаг дахь Дорноговь аймаг дахь Нийгмийн даатгалын хэлтсийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Нийгмийн даатгалын хэлтсийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “үр нөлөөтэй” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

### 3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 0.2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлангийн нийт зардлын 29,328,053.1 мянган төгрөгөөс 0.2 хувиар буюу 58,656.1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлт болон хувь хэмжээг өөрчлөөгүй. Суурь үзүүлэлтийг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардал болох 62,360,626.4 мянган төгрөгөөс төлөвлөлтийн үе шатанд сонгосон хувь хэмжээгээр тооцож, материаллаг байдлын хэмжээг 124,721.2 мянган төгрөгөөр тогтоов.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Нийгмийн даатгалын сангийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 5,399,960.4 мянган төгрөгөөр буюу 76.7 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материалын данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	5,414,306.3	6,475,253.1	1,060,946.8
Авлага	1,167,847.8	5,515,780.3	4,347,932.5
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	11,367.8	17,255.7	5,888.0
Үндсэн хөрөнгө	444,547.2	429,740.4	(14,806.8)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>7,038,069.1</b>	<b>12,438,029.5</b>	<b>5,399,960.4</b>
Өр төлбөр	428,091.7	142,289.3	(285,802.4)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	6,609,977.4	12,295,740.2	5,685,762.8
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>7,038,069.1</b>	<b>12,438,029.5</b>	<b>5,399,960.4</b>

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 6,475,253.1 мянган төгрөг болж 1,060,946.8 мянган төгрөгөөр өссөн нь Монголын төмөр зам хувь нийлүүлсэн нийгэмлэгийн харьяа байгууллагуудын шимтгэл тайлант оны 12 дугаар сарын сүүлийн өдөр сангийн дансанд шилжин орсноос шалтгаалжээ.

Авлага дансны үлдэгдэл 5,515,780.3 мянган төгрөг болж 4,347,932.46 мянган төгрөгөөр өссөн нь Ковид-19 цар тахалтай холбоотойгоор үйл ажиллагаа нь зогссон, орлого буурсан аж ахуйн нэгж иргэнд төрөөс үзүүлсэн НДШ-ийн чөлөөлөлт, дэмжлэгийн санхүүжилт болох 3,971,505.5 мянган төгрөгийг улсын төсвөөс нийгмийн даатгалын санд

төвлөрүүлээгүй, мөн цар тахлын улмаас аж ахуйн нэгжийн орлого буурч, нийгмийн даатгалын шимтгэлийг бүрэн төлөөгүй зэргээс шалтгаалжээ.

Авлага дансны үлдэгдэлд 2014-2015 онуудад үүссэн, он удаан жил болсон 17,344.2 мянган төгрөгийн 5 байгууллагаас авах НДШ-ийн авлага байна. Нийт авлагаас барагдах боломжгүй эрсдэлтэй 14,747.2 мянган төгрөгийн авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 17,255.7 мянган төгрөг болж 5,888.0 мянган төгрөгөөр өссөн нь НДЕГ-аас 2020 онд ирүүлсэн хөрөнгө болон 12 дугаар сард худалдан авсан ариутгал, халдваргүйжүүлэлтийн материалыг бүрэн зарцуулаагүйтэй холбоотой байна. Мөн түлш, шатахууны талоныг бүрэн зарцуулаагүйтэй холбоотой байна.

Бараа материалын үлдэгдэл нөөцөлсөн, ашиглалтгүй байгаа хөрөнгө бүртгэгдээгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 429,740.4 мянган төгрөг болж, 14,806.8 мянган төгрөгөөр буурсан нь /үлдэгдэл өртгөөрөө/ тайлант онд 47,027.4 мянган төгрөгийн элэгдлийн зардлыг тооцсон нь үлдэгдэл өртгийг буурахад нөлөөлсөн байна. Үндсэн хөрөнгийн орлогод үнэ төлбөргүй шилжиж ирсэн 32,220.7 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэгдсэн байна.

Үндсэн хөрөнгийн зарлагад 22,867.1 мянган төгрөгийн анхны өртөгтэй, мөн дүнгээр элэгдэл байгуулсан, үлдэгдэл өртөггүй үндсэн хөрөнгө акталсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 142,289.3 мянган төгрөг болж, 285,802.4 мянган төгрөгөөр буурсан нь 2019 онд олгогдоогүй үлдсэн тэтгэмжийг 2020 онд бүрэн олгосонтой холбоотой байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 12,295,740.2 мянган төгрөг болж, 5,685,762.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын санд төвлөрүүлсэн шилжүүлэг тайлант буурснаас шалтгаалжээ /уг шилжүүлгийг санхүүгийн үр дүнгийн тайланд зардлаар бүртгэдэг/.

Нийгмийн даатгалын сангийн 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 14,944,909.2 мянган төгрөгөөр буюу 28.2 хувиар өссөн байна.

Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого өмнөх оноос 6,989,755.4 мянган төгрөгөөр, нийгмийн даатгалын сангаас авах шилжүүлэг 7,760,560.5 мянган төгрөгөөр өссөн байна.

Нийт зардал өмнөх оноос 9,944,400.9 мянган төгрөгөөр буюу 19 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн зардлууд байна. Энэ нь Засгийн газрын 2020 оны 24 дүгээр тогтоолын дагуу өндөр насны тэтгэвэр тогтоолгосон зарим иргэний сарын тэтгэврийн хэмжээг 50.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орж, сайн дурын даатгуулагч эхэд олгох 70 хувиар тооцон олгодог байсан жирэмсэн, амаржсаны тэтгэмжийг 100 хувиар тооцож олгосонтой холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан болон нягтлан бодох бүртгэлийн залруулга хийгдсэн гүйлгээ бүртгэгдээгүй байна.

### **3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд байгууллагын үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 58,507,731.5 мянган төгрөгөөр зарлагыг мөн дүнгээр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс үйл ажиллагааны зардлыг 183,136.2 мянган төгрөгөөр, сангийн зардлыг 5,990,547.9 мянган төгрөгөөр бууруулж, 52,517,183.6 мянган төгрөгөөр баталсан байна. Өмнөх оны батлагдсан төсвөөс материаллаг өөрчлөлт гараагүй болно.

### Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг 698,534.7 мянган төгрөгийн төсөв, нийгмийн даатгалын тэтгэвэр тэтгэмжийн санхүүжилтэд 51,818,648.9 мянган төгрөг батлагдаж, үүнийг нийгмийн даатгалын сангаас 52,517,183.6 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр нийгмийн даатгалын сангаас 18,120,300.0 мянган төгрөгийн, үндсэн болон туслах үйл ажиллагаанаас 44,917,931.9 мянган төгрөгийн, үйл ажиллагааны зардлын санхүүжилтэд нийгмийн даатгалын сангаас 698,534.7 мянган төгрөг, 63,736,766.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаа болон нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмжийн зардалд нийт 51,252,214.6 мянган төгрөгийг зарцуулж, 11,423,605.3 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна. Мөнгөн хөрөнгийн цэвэр мөнгөн гүйлгээ нь 1,060,946.8 мянган төгрөг байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 51,232,403.9 мянган төгрөг буюу 98.8 хувьтай байгаа нь тэтгэврийн даатгалын шимтгэлийн зардлыг 574,290.6 мянган төгрөгөөр, бараа, ажил үйлчилгээний зардлыг /ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж зэрэг/ 12,622.1 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

### Улсын төсөвт төвлөрүүлэх орлого

Эрүүл мэндийн даатгалын шимтгэл 6,272,000.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 7,867,522.6 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 25 хувиар давж биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөв	Гүйц	Зөрүү	Хувь
Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	6,272,000.0	7,867,522.6	-1,595,522.6	125.4

### Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Засаг даргын нөөц хөрөнгөөс 1,000.0 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас 4,674.4 мянган төгрөг, нийт 5,674.4 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс ариутгах, халдваргүйжүүлэх болон албан хаагчдын дархлааг дэмжих бүтээгдэхүүн худалдан авахад 4,062.0 мянган төгрөг, НДЕГ-аас зарлагдсан сайн дурын даатгуулагчийн болзолт уралдааны шагналд 612.4 мянган төгрөг, ажилтнуудын нийгмийн

асуудал шийдвэрлэх хүрээнд 1,000.0 мянган төгрөг, нийт 5,674.4 мянган төгрөгийг зарцуулсан байна.

### 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд нийгмийн даатгалын сангийн үйл ажиллагаатай холбоотой оруулбал зохих 6,643 мэдээллээс хугацаандаа оруулсан 6,640 мэдээлэл, хугацаа хоцроож байршуулсан 3 мэдээлэл байна. Шилэн дансны цахим системд огт байршуулаагүй мэдээлэл байхгүй байна. Хугацаа болоогүй 2 мэдээлэл байна.

Тайлант хугацаанд нийгмийн даатгалын хэлтсийн үйл ажиллагаатай холбоотой оруулбал зохих 83 мэдээллээс хугацаандаа оруулсан 76 мэдээлэл, хугацаа хоцроож байршуулсан 7 мэдээлэл байна. Шилэн дансны цахим системд огт байршуулаагүй мэдээлэл байхгүй байна.

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1,617,211.4 мянган төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгсөн ба зөвлөмжийн хэрэгжилт 66.7 хувьтай байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

/мянган.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-				-
Албан шаардлага	-	-	-				-
Зөвлөмж	3	1,617,211.4	2	21,271.9	1	1,595,939.5	66.6
Нийт дүн	3	1,617,211.4	2	21,271.9	1	1,595,939.5	66.6

Өмнөх онд өгөгдсөн 3 зөвлөмжөөс дараах зөвлөмж хэрэгжээгүй байна. Үүнд, 2019 оны эцэст нийт 1,595,939.5 мянган төгрөгийн өглөг, авлагатай ажилласан ба уг зөрчилд өглөг, авлагагүй ажиллаж зөвлөмжийг өгсөн байна. Тайлант онд өмнөх оны үлдэгдлээр бүртгэгдсэн өглөг, авлага барагдсан боловч 2020 онд нэмж өглөг болон авлага үүсч, 2020 оны жилийн эцэст 5,658,069.6 мянган төгрөгийн өглөг, авлагын үлдэгдэл бүртгэгдсэн. Энэхүү зөвлөмжийг хэрэгжүүлээгүй гэж үзсэн боловч, өглөг, авлагын үлдэгдэлд шинжилгээ хийж үзэхэд зайлшгүй үүссэн өглөг, авлагын дүн ихэнх хувийг эзэлж байна. Иймд уг зөрчилд албан шаардлага тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1,547.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, уг зөрчилд 1 албан шаардлага хүргүүлсэн. Аудитын явцад хийсэн залруулга байхгүй ба төлбөрийн акт, зөвлөмж өгөгдөөгүй болно.

#### **Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил**

Аудитаар 1,547.0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 1,547.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлсэн. Үүнд:

1. Багаж, техник, хэрэгсэл худалдан авах зардлаас автомашинд 1,547.0 мянган төгрөгийн сэлбэг хэрэгсэл худалдан авч, төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-ын “Төсвийн шууд захирагч нь ... батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” заалт, Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар батлагдсан журмын холбогдох заалттай нийцэхгүй, үнэн зөв батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлагыг хүргүүлэв.

### **3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД**

Тус байгууллагад ашиглагдаж байгаа санхүүгийн программ хангамж нь Сангийн яамны бүртгэлд бүртгэгдээгүй байна. Иймд Сангийн яамны зөвшөөрөлтэй санхүүгийн программыг ашиглахад анхаарах шаардлагатай байна.

#### 4. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: <b>2020</b>	Аудитын нэр: <b>Нийгмийн даатгалын сангийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</b>	Аудитын код: <b>ДГА-2021/7/СТА-ТТЗ</b>
Шалгагдсан байгууллагын нэр:	<b>Дорноговь аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс</b>	Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Төсвийг зориулалт бусаар зарцуулсан	1,547.0	Албан шаардлага	Дарга, ерөнхий нягтлан бодогч	Л.Шагдарсүрэн, Б.Мөнхбат
<b>ДҮН</b>		<b>1,547.0</b>			